

ХАМТАРСАН АЖЛЫН ХЭСГИЙН ТОХИРОЛЦООГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ГЭРЭЭ

2024 оны 4 дүгээр сарын 18

Улаанбаатар хот

Энэхүү Хамтарсан ажлын хэсгийн тохиролцоог хэрэгжүүлэх гэрээ (цаашид “Гэрээ” гэх)-г 2024 оны 4 дүгээр сарын 18-ны өдөр нэг талаас Оюу Толгой ХХК (цаашид “ОТ ХХК” гэх), нөгөө талаас Оюу Толгой ХХК-ийн Уул уурхайн ажилтны Үйлдвэрчний эвлэлийн хороо ТББ (цаашид “ҮЭХ” гэх) (цаашид хамтад нь “Талууд” гэх) нар дор дурдсан нөхцөлөөр харилцан тохиролцож байгуулав.

Нэг. Ерөнхий үндэслэл

1.1. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны 3 дугаар сарын 17-ны өдрийн А/49 дүгээр тушаалаар батлагдсан "Дундаж цалин хөлс тодорхойлох журам"-ын 2.2 дахь хэсэгт оруулсан нэмэлт (“Журмын нэмэлт”)-ийг хэрэгжүүлэхээр ажиллаж байгаа тухай мэдэгдлийг ОТ ХХК-иас ҮЭХ-нд 2024 оны 2 дугаар сарын 07-ны өдөр хүргүүлсэн. Энэхүү мэдэгдэлтэй холбоотойгоор ОТ ХХК болон ҮЭХ харилцан тохиролцож 2024 оны 3 дугаар сарын 6-ны өдөр Хамтарсан ажлын хэсэг (“Хамтарсан ажлын хэсэг”) байгуулсан.

1.2. Хамтарсан ажлын хэсэг хамтран ажиллах зорилгоо “Дундаж цалин хөлсний бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах шийдвэрийн суурь шалтгааныг тогтоож, асуудлыг шийдэх дараагийн алхмуудыг тодорхойлох” гэж тохирсон.

1.3. Хамтарсан ажлын хэсэг Гэрээний 1.2-т заасан зорилгын хүрээнд Журмын нэмэлтийг хэрэгжүүлэх болсон суурь шалтгаан нөхцөлүүдийг тодорхойлон “Хамтарсан дүгнэлт”-ийг гаргаж, нийт ажилтнуудад танилцуулсан.

1.4. Журмын нэмэлтийг хэрэгжүүлэх шийдвэрийн улмаас ажилтнуудад нөлөөлөх нөлөөллийг бууруулах, Хамтарсан ажлын хэсгийн тохиролцсон зорилго болох асуудлыг шийдэх дараагийн алхмуудыг тодорхойлох ажлын хүрээнд ОТ ХХК Гэрээний 2 дугаар зүйлд заасан тохиролцооны саналыг ҮЭХ-нд хүргүүлсэн. ҮЭХ нь уг саналыг хэлэлцэж, нийт тэргүүлэгч гишүүдийн олонхийн саналаар дэмжсэн тул Талууд хэрэгжүүлэхээр харилцан тохиролцов.

Хоёр. Хамтарсан ажлын хэсгийн харилцан тохиролцсон зүйл

2.1. Талууд 2024 оны 4 дүгээр сарын 17-ны өдөр Хамтарсан ажлын хэсгийн нийт гишүүд, ҮЭХ-ны бусад тэргүүлэгч гишүүдийг оролцуулсан өргөтгөсөн уулзалт хийсэн бөгөөд уг уулзалтаар дараах зүйлийг харилцан тохиролцов. Үүнд:

- 2.1.1 ОТ ХХК-ийн нийт ажилтнуудын үндсэн цалинг 2024 оны 4 дүгээр сарын 10-ны өдрөөс 4 (дөрөв) хувиар нэмж, 2024 оны 5 дугаар сарын 10-ны өдрөөс олгох;
- 2.1.2 Эрүүл мэнд, гэнэтийн ослын даатгалд ОТ ХХК-ийн ажилтнаас гадна нэмэлтээр гэр бүлийн 2 гишүүнийг 2024 оны 8 дугаар сард багтаан хамруулах;
- 2.1.3 Ажилтны эрүүл мэнд, сайн сайхан байдалд зориулан амралт сувиллын хөнгөлөлт болох 1,000,000 (нэг сая) төгрөгийг 2024 оны 4 дүгээр сарын 25-ны өдрөөс 1 (нэг) жилийн хугацаанд ээлжийн амралтаа биеэр эдлэх эсхүл ростерийн амралтын үед 1 (нэг) удаа олгох;
- 2.1.4 Байнга ажилладаг газар болон гэрийнхээ хооронд өдөр тутам ирж буцах боломжтой ажил амралтын хуваарьтай ажилтны хоол унааны зардалд нэмэр болох зорилгоор олгодог Хоол, унааны хөнгөлөлтийг 2024 оны 4

дүгээр сарын 10-ны өдрөөс эхлэн 300,000 /гурван зуун мянга/ төгрөгөөр нэмэх;

- 2.1.5 Инженер техникийн ажилтнуудын албан тушаалын зэрэглэлийг нягтлах, РиоТинтогийн жишгийг харгалзан өөрчлөлтийг оруулах зорилго бүхий төслийн цар хүрээ болон төлөвлөгөөг боловсруулах хамтарсан ажлын хэсгийг байгуулах ажлуудыг 2024 оны 2 дугаар улиралд багтаан хийх, 2024 оны 3 дугаар улиралд багтаан албан тушаалын зэрэглэлийн өөрчлөлтийн хэрэгжилтийг эхлүүлэх;
- 2.1.6 Ажилтны илүү цаг болон шөнийн ээлжийн нэмэгдэл хөлсийг тооцоход хэрэглэх “дундаж цалин хөлс”-ний бүрэлдэхүүнийг дараах нэмэгдэл, нэмэгдэл хөлс, цалингаар 2024 оны 4 дүгээр сарын 10-ны өдрөөс тооцох ба энэ бүрэлдэхүүнийг ОТ ХХК-ийн цалингийн систем болон холбогдох журамд тусгана:
- 2.1.6.1 Үндсэн цалин;
- 2.1.6.2 Уртын ээлжийн нэмэгдэл;
- 2.1.6.3 Хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлийн нэмэгдэл;
- 2.1.6.4 Засвар үйлчилгээний зогсолтгүй үйл ажиллагааны нэмэгдэл хөлс;
- 2.1.6.5 Зогсолтгүй үйл ажиллагааны нэмэгдэл хөлс;
- 2.1.6.6 Ээлжийн амралтын цалин.

Гурав. Бусад зүйл

3.1. Энэхүү Гэрээ нь Талууд гарын үсэг зурсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

3.2. Энэхүү гэрээ нь Талуудын хооронд өмнө нь солилцож байсан албан бичиг, хийгдэж байсан яриа хэлэлцээг бүрэн орлож, Талуудын эцсийн харилцан ойлголцлыг бүрэн илэрхийлнэ.

3.3. Талууд Гэрээнд харилцан тохиролцсон тохиролцоотой холбоотой аливаа маргааныг зөвшилцлийн үндсэн дээр шийдвэрлэхийг эрмэлзэнэ.

3.4. Гэрээ нь Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу зохицуулагдана.

3.5. Гэрээг Англи, Монгол хэл дээр үйлдэх бөгөөд Гэрээний агуулга, утга буюу тайлбартай холбоотой зөрүү гарсан тохиолдолд Монгол эхийг баримтална.


3.6. Гэрээ нь ҮЭХ-ны дарга болон тэргүүлэгч гишүүд өөрчлөгдсөн ч хүчин төгөлдөр хэвээр үйлчилнэ.

ГЭРЭЭГ БАЙГУУЛСАН:

ОЮУ ТОЛГОЙ ХХК-ИЙГ
ТӨЛӨӨЛЖ:


ҮЭХ-Г ТӨЛӨӨЛЖ:

М.Ганболд



Баяжуулалтын сайжруулалт хариуцсан
тэргүүн зөвлөх

Г.Идэр




Даргыг түр орлон гүйцэтгэгч

Э.Анхбаяр 
Хөрөнгө, материалын менежмент
хариуцсан менежер

Б.Хэнмэдэхбаяр 
Тэргүүлэгч гишүүн

С.Цогжавхлан 
Уурхайн үйл ажиллагааны менежер

А.Үнэнбат 
Тэргүүлэгч гишүүн

А.Алтаншагай 
Гүний уурхайн суурин тоног
төхөөрөмжийн засвар үйлчилгээний
менежер

П.Өнөболд 
Тэргүүлэгч гишүүн

Ж.Эрдэнэбилэг 
Хөдөлмөрийн харилцаа хариуцсан
менежер


Г.Билгүүдэй 
Тэргүүлэгч гишүүн

С.Мөнгөнчимэг 
Олон талт хамтын ажиллагааны
менежер


Э.Хатанбаатар 
Тэргүүлэгч гишүүн

Б.Энхмаа 
Хуульч


П.Гэрэлмандах 
Тэргүүлэгч гишүүн

М.Энхтайван 
Тэргүүлэгч гишүүн


Н.Эрдэнэбаяр 
Тэргүүлэгч гишүүн

Ц.Очирбат 
Тэргүүлэгч гишүүн

Б.Наранбаяр 
Тэргүүлэгч гишүүн


Д.Золжаргал  _____
Тэргүүлэгч гишүүн

Т.Оюун-Эрдэнэ  _____
Тэргүүлэгч гишүүн

Р.Бадрал  _____
Тэргүүлэгч гишүүн

Г.Ууганбямба  _____
Тэргүүлэгч гишүүн

Д.Чулуунбаяр  _____
Тэргүүлэгч гишүүн

Т.Тэнгэс  _____
Тэргүүлэгч гишүүн

2024 оны 4 дүгээр сарын 18-ны өдөр